



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 32

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 32,976,450 /гучин хоёр сая есөн зуун далан зургаан мянга дөрвөн зуун тавь/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 13-90 ДУЭ улсын дугаартай SONATA6 маркийн автомашины худалдах доод үнийг 1,000,000 /нэг сая/ төгрөгөөр, 73-46 ДУА Sunny маркийн автомашиныг худалдах доод үнийг 800,000 /найман зуун мянга/ төгрөгөөр хавсралтын дагуу тогтоон дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа (О.Амарсанаа)-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын
03-ний өдрийн 32 тогтоолын хавсралт

Аймгийн Цагдаагийн газрын нээлттэй дуудлага худалдаагаар худалдаалах эд хөрөнгийн жагсаалт

Д/Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Дуудлага худалдааны үнэ
			Сери	дугаар						
1	Суудлын	supu	ДУА	73-46	2003	6/30/2012	192854	8,000,000.00	8,000,000.00	800,000
2	Суудлын	SONATA-6	ДУЭ	13-90	1998	1/12/2006	346816	24,976,450.00	24,976,450.00	1,000,000
Нийт дүн										
								32,976,450.00	32,976,450.00	1,800,000
								/гучин хоёр сая	/гучин хоёр сая	/нэг сая найман
								есөн зуун далан	есөн зуун далан	зуун мянга/
								зургаан мянга	зургаан мянга	зуун мянга/
								дөрвөн зуун	дөрвөн зуун	тавь/
								тавь/	тавь/	тавь/